


## ТИВ ДАМНАСАН ХӨРШҮҮД



Монгол Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосын 50 жилийн ой энэ онд тохиож байна. Энэ хүрээнд “Ой тэмдэглэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтоолоор ажлын хэсэг байгуулагдан, жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Кембрижийн их сургуулийн Монгол, Өвөр Азийн судалгааны төвийн эрдэмтэн, судлаачид хамтран хоёр талын харилцааны түүхийн холбогдолтой “Тив дамнасан хөршүүд” 2 боть ном бүтээхээр ажиллаж байна.

Энэхүү номын “Монгол-Британий харилцааны баримтат түүх” хэмээх Монгол, Британий харилцааны сүүлийн зуун жилийн түүхийг гол төлөв түүх-архивын ховор чухал баримт бичгүүдээр дамжуулан харуулсан тэргүүн дэвтэр 2013 оны 3 дугаар сард Британид хэвлэгдэн олон нийтийн хүртээл боллоо.

Монгол Улсын Үндэсний төв архив, Гадаад харилцааны төв архив, МАХН-ын баримтын төв, Британи дахь Монгол Улсын ЭСЯ, Британий Үндэсний архив, Британий Үндэсний номын санд хадгалагдаж буй манай хоёр улсын харилцааны түүхэнд холбогдох арвин баримт бичгээс сонголт хийн, монгол хэл дээрх 45, англи хэл дээрх 70 гаруй баримт, судлаачдын хувийн цуглуулгаас 20 гаруй захидлыг 5 бүлэгт хуваан оруулсан байна.

- “Их тоглоомын дипломат бодлого” хэмээх нэгдүгээр бүлэгт Британи, Оросын хооронд Хятад дахь төмөр замын асуудлаар солилцсон ноотууд (1899), Монголын тухай санамж бичиг (1907), Монголын хил хязгаарыг шийдэх томъёо/ далд төлөвлөгөө (1907), Монгол Улсын тусгаар тогтнолыг зарлан мэдэгдэж, гэрээ байгуулан найрамдалт харилцаа тогтоохыг хүсч Британи улсад илгээсэн Гадаадын Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэгч Яамны бичиг (1912), Английн худалдаачид Монголд алт, зэс, төмөр зэрэг өнгөт металлын уурхай нээж ажиллах зөвшөөрөл хүссэн тухай Сангийн яамнаас Гадаад яаманд илгээсэн бичиг (1923) зэрэг одоогоос нэгэн

зуун жилийн өмнөх хоёр улсын би биендээ чиглэсэн хандлагыг илэрхийлсэн эртний баримт бичгүүд багтжээ.

- “Хүлээн зөвшөөрөх яриа хэлэлцээ” хэмээх удаах бүлэгт харилцаа тогтоохтой холбогдсон 1960-аад оны эхэн үеийн хоёр талын дипломат албадын хооронд харилцсан болон мэдээллийн чанартай олон сонирхолтой баримт бичиг оржээ.

- “Хүйтэн дайн, дотно нөхөрлөл” гуравдугаар бүлэгт улс төр үзэл суртлын хүнд бэрх сөргөлдөөнтэй цаг үеийн харилцааны онцлогыг илтгэн харуулж чадахуйц Англи-Монголын нийгэмлэгийн тухай баримтууд (1966), Оуэн Латтимор, Базарын Ширэндэв нарын харилцсан захидал (1963-1978), Өргөнгөө ононгоос Базарын Ширэндэвт бичсэн захидлууд (1968-1979), болон Монгол Улсын түүхэнд өндөр хөгжилтэй өрнөдийн их сургуулиас хамгийн анх цол хүртсэн академич Б.Ширэндэвийн Лийдсийн Их сургуулийн хүндэт доктор цол олгосонтой холбогдох (1970) баримт бичгүүдийг гэрэл зургийн хуулбараар оруулжээ.

- “Ардчилал ба эдийн засгийн түншлэл” хэмээх дөрөвдүгээр бүлэгт хоёр талын харилцааны шинэ үеийн түүхийг илтгэсэн Монгол Улсын Засгийн газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын харилцааны тухай хоёр Засгийн газрын хамтарсан тунхаглал (1996), Британий Гүнж Анна, нөхрийн хамт Монгол Улсад хийсэн айлчлалын тухай (1993) болон харилцааны цоо шинэ шатанд гарсныг нотлох Монгол Улсын Засгийн газар, “Айвенхоу майнз монголиа Инк” ХХК, “Айвенхоу майнз лимитед”, “Рио Тинто интернэшнл холдингс лимитед” компани хооронд байгуулах Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурах эрх олгох тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол (2009), “Монгол Улсын Засгийн газар, ИБУИНВУ-ын Кембрижийн Их Сургуулийн Кембрижийн олон улсын шалгалтын төв хооронд бага дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурах эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж (2011), Монгол Улс болон ИБУИНВУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны ойг тэмдэглэх тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол (2012) зэрэг олон чухал баримт багтжээ.

- Төгсгөлийн тавдугаар бүлэгт хоёр улсын Засгийн газар болон байгууллага хооронд 1966-2012 оны хооронд байгуулсан 25 гэрээний англи эх, хавсралт хэсэгт хоёр талын төрийн албан ёсны айлчлалууд, Монголоос Британид, Британиас Монголд томилогдон ажиллаж байсан элчин сайдын нэрсийн жагсаалтыг оруулсан

байна.

Тэргүүн дэвтэрийн редактороор элчин сайд, доктор Б.Алтангэрэл, доктор У.Булаг, доктор Д.Шүрхүү, доктор С.Чулуун, судлаачаар доктор Д.Золбоо, доктор Т.Баасанжав, зохицуулагч редактороор хатагтай Л.Пичи нар ажилласан байна.

Энэ оны сүүлийн хагаст хэвлүүлэхээр бэлтгэж буй Дэд дэвтэрт түүхэн харилцааны ерөнхий өгүүлэмж, XIII зуунаас өнөө хүртэлх харилцааны түүхэнд тохиосон гол гол үйл явдлын хэлхээс, хоёр улсын харилцаанд идэвхитэй оролцсон байгууллага, хувь хүн болон алдар цуутай хүмүүсийн үйл ажиллагаа, хоёр ард түмний найрамдалд хувь нэмрээ оруулсан хүмүүсийн дурсамж, түүхэн гэрэл зургийн тайлбар гэх мэт олон зүйлийг багтаах юм.

Бэлтгэсэн Д.Золбоо (Ph.D)